



**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

**ТӨВ АЙМГИЙН БАЯНЧАНДМАНЬ  
СУМЫН "МСҮТ"-ИЙН ЗАХИРАЛ  
Д.МӨНХБААТАР ТАНАА**

2013.03.18 № 02/13 УАГ-САГ/2013/95/СТГА-ТЧЗ

**Худалдан авалтын тухай**

Төв аймгийн Баянчандмань сумын "МСҮТ"-ийн 2012 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ. Үүнд: 21,732.4 мянган төгрөгийн бараа материал болон 45,177.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгүүд худалдан авсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7.3 "Захиалагч энэ хуулийн 8.1.2-т заасан босго үнээс бага төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг энэ хуулийн 7.1 дэх хэсэгт заасан журмыг мөрдөхгүйгээр шууд худалдан авч болно.", 8.1-д "Засгийн газар нь барааны, ажлын, үйлчилгээний гэсэн ангилал тус бүрээр босго үнийг тогтооно" гэсэн заалтыг, Засгийн газрын "Босго үнэ батлах тухай" 2006 оны 22 тоот тогтоолын хавсралтад "Барааг шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 1 сая төгрөг" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

"Төрийн аудитын тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 1-ийн 12 дугаар заалт, Монгол улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.1 дүгээр заалтыг үндэслэн дээрх алдаа, зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй ажиллахыг Төв аймгийн Баянчандмань сумын "МСҮТ"-ийн захирал Д. Мөнхбаатар, нягтлан бодогч Л. Одонгуа нарт үүрэг болгож, албан шаардлага хүргүүлж байна.

Албан шаардлагын биелэлтийг 2013 оны 06 дугаар сарын 25 -ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг мэдэгдье.

АУДИТОР



Д. ГАНДОЛГОР

070037